

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

№ ... *19/54*

Улаанбаатар хот

Ёс зүйн дүрэм батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6.7 дахь хэсэг, ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Ёс зүйн дүрмийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлж, Компанийн үйл ажиллагаанд бүхий л шатанд нийтээр даган, мөрдлөг болгон ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-т даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

№ ...19/55

Улаанбаатар хот

Эрсдэлийн удирдлагын бодлого батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6.7 дахь хэсэг, ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлогыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-т үүрэг болгосугай.
3. Эрсдэлийн удирдлагын бодлого батлагдсантай холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай өөрчлөлтийн саналыг ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-т даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо /Б.Дэлгэржаргал/, Аудитын хороо /Ж.Жаргалсүрэн/-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

№ *19/56*

Улаанбаатар хот

**Зээл, түүнтэй адилтгах активыг ангилах,
зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах,
зарцуулах бодлого батлах тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)–ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)–ийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6.7 дахь хэсэг, ТУЗ–ийн 2019 оны 10 дугаар сарын 23–ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК–ийн Зээл, түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Зээл, түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогыг хэрэгжүүлэх, түүнд нийцүүлэн холбогдох журам, заавар, загвар аргачлалыг боловсруулан, баталж, мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)–т үүрэг болгосугай.
3. Зээл, түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогын хэрэгжилт, зээл, түүнтэй адилтгах активт байгуулсан эрсдэлээс хамгаалах сан, түүний зарцуулалтыг ТУЗ–ийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/–т даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ–ийн Эрсдэлийн удирдлагын хороо /Б.Дэлгэржаргал/–д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр

№ *19/57*

Улаанбаатар хот

Аудитын байгууллага сонгох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь хэсэг, ТУЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. Аудитын байгууллагатай гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулж ажиллах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д олгосугай.
3. Аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхэд аудитын байгууллагыг ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

